



“МОНГОЛЫН ИПОТЕКИЙН КОРПОРАЦИ ОССК” ХХК-ИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАНЫ 20 ЖИЛИЙН ОЙН НЭРЭМЖИТ ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Орон сууц, ипотекийн санхүүжилт, ногоон хөгжил, санхүүгийн технологи зэрэг сэдвийн хүрээнд оюутнуудын судалгаа, шинжилгээний ур чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж, шинэлэг санаа, практик ач холбогдол бүхий судалгааны ажлыг дэмжих зорилготой. Түүнчлэн залуу үеийн орон сууцны хүлээлт, санхүүгийн боловсрол, ирээдүйн хэрэгцээ, шаардлагыг оюутнуудын өөрсдийн өнцгөөс судлан илэрхийлэх боломжийг бүрдүүлнэ.

Хоёр. Сэдвийн хамрах хүрээ

Оролцогчид дараах сэдвүүдийн аль нэгээр судалгааны бүтээл, илтгэл бэлтгэнэ:

2.1 Залуу үе ба ипотекийн ирээдүй

Залуу үеийн орон сууцны хэрэгцээ, хүлээлт, санхүүгийн бэлэн байдал, хуримтлалын дадал, санхүүгийн боловсролын түвшин болон ипотекийн зээлд хамрагдахад тулгарч буй боломж, сорилтын талаарх судалгаа.

2.2 Ногоон ипотекийн зээл: Тогтвортой хөгжил ба ирээдүйн хот байгуулалт

Ногоон орон сууц, эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж, байгаль орчинд ээлтэй хот байгуулалт, тогтвортой хөгжлийг дэмжих санхүүгийн шийдэл болон ногоон ипотекийн зээлийн боломж, үр нөлөөний талаарх судалгаа.

2.3 Санхүүгийн хүртээмж ба хиймэл оюунд суурилсан зээлийн үнэлгээ

Санхүүгийн түүх багатай эсхүл санхүүгийн түүхгүй иргэдийн зээлжих чадварыг үнэлэхэд альтернатив өгөгдөл, их өгөгдөл болон хиймэл оюунд суурилсан шийдлүүдийг ашиглах боломж, үр нөлөөний талаарх судалгаа.

Гурав. Оролцогчдод тавигдах шаардлага

- 3.1. Монгол Улсын Их Сургууль (МУИС) болон Санхүү, Эдийн Засгийн Их Сургууль (СЭЗИС)-ийн бакалаврын түвшний III, IV курсэд суралцаж буй оюутнууд хамрагдана.
- 3.2. Оролцогч ганцаарчлан эсхүл хоёроос ихгүй гишүүнтэй багаар оролцож болно.
- 3.3. Ирүүлж буй бүтээл нь оролцогчийн өөрийн бие даан гүйцэтгэсэн, өмнө нь хэвлэгдээгүй, нийтлэгдээгүй эсхүл бусад уралдаан, эрдэм шинжилгээний хуралд шагналт байрт шалгарч байгаагүй бүтээл байна.

Дөрөв. Судалгааны бүтээлийн бүтэц ба техникийн шаардлага

4.1. Бүтэц

- Гарчиг (бүтээлийн нэр);
- Товч хураангуй (монгол, англи хэлээр, тус бүр 150-200 үг), 3-5 түлхүүр үг;
- Удиртгал (сэдвийн үндэслэл, ач холбогдол, асуудлын тодорхойлолт, судалгааны зорилго);
- Онолын үндэслэл болон холбогдох судалгааны тойм;
- Судалгааны өгөгдөл, арга зүй;
- Судалгааны үр дүн, шинжилгээ;
- Дүгнэлт, санал зөвлөмж;
- Ашигласан материалын жагсаалт (APA стандарт)
- Шаардлагатай тохиолдолд хавсралт;
- Судалгааны бүтээл нь нүүр хуудас, ашигласан материалын жагсаалт болон хавсралтаас бусад хэсгийг тооцон 10–15 нүүр байх;
- Судалгааны нүүр хуудсанд зохиогчийн овог, нэр, холбоо барих утасны дугаар, цахим шуудгийн хаяг, сургуулийн нэр, курс, мэргэжлийг бичих.

4.2. Форматын шаардлага

- Файлын формат: “Microsoft Word” (.docx), A4 хэмжээтэй;
- Фонт: “Times New Roman”, үсгийн хэмжээ 12pt, мөр хоорондын зай 1.5;

- Хүснэгт, зураг, график бүр дугаар, нэр, шаардлагатай тохиолдолд эх сурвалжтай байна;
- Эшлэл болон ашигласан материалын жагсаалтыг “АРА 7” дахь хэвлэлийн стандартын дагуу бичнэ.
- Судалгааны бүтээл нь оролцогчийн бие даан гүйцэтгэсэн бүтээл байх бөгөөд бусдын бүтээл, мэдээлэл, санаа, хиймэл оюун ухаанаар үүсгэсэн агуулгыг ашигласан тохиолдолд эх сурвалжийг зохих журмын дагуу дурдана. Эх сурвалжгүй хуулбарласан бүтээлийг шалгаруулалтаас хасна.

Тав. Уралдааны үе шат, зохион байгуулалт

5.1. Уралдааныг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

Үйл ажиллагаа	Хугацаа
Бүтээл хүлээн авах эцсийн хугацаа	2026 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 17:00 цаг хүртэл
Эхний шатны шалгаруулалтын дүнг шүүгчдийн багийн үнэлгээнд үндэслэн мэдэгдэх	2026 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор
Эцсийн шатны илтгэл, хэлэлцүүлэг, шагнал гардуулах ёслол	2026 оны 10 дугаар сарын 20-ны өдөр

5.2. Судалгааны бүтээлийг iltgel@mik.mn цахим шуудангийн хаягаар цахим хэлбэрээр эсхүл “Монголын Ипотекийн Корпораци ОССК” ХХК-ийн оффист цаасан хэлбэрээр хүлээн авна. Оролцогч нь бүтээлээ дээрх хэлбэрүүдийн аль нэгээр ирүүлнэ.

5.3. Цаасан хэлбэрээр ирүүлэх тохиолдолд судалгааны бүтээлийг битүүмжлэн дараах хаягаар хүлээлгэн өгнө:

Хаяг: Улаанбаатар хот 15160, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Д.Сүхбаатарын талбай гудамж, 11 тоот, Монголын Ипотекийн Корпорацийн байр.

- 5.4. Цаасан хэлбэрээр ирүүлсэн судалгааны бүтээлийг оролцогчид буцаан олгохгүй болохыг анхаарна уу.
- 5.5. Хугацаа хожимдуулж ирүүлсэн болон энэхүү удирдамжид заасан шаардлагыг хангаагүй судалгааны бүтээлийг хүлээн авахгүй болно.
- 5.6. Эцсийн шатанд шалгарсан оролцогчдод хурлын байршил, эхлэх цаг, илтгэлийн дараалал болон зохион байгуулалттай холбоотой бусад мэдээллийг урьдчилан хүргүүлнэ.
- 5.7. Хурал нь нээлтийн үйл ажиллагаа, шалгарсан судалгааны бүтээлүүдийн танилцуулга, хэлэлцүүлэг, шүүгчдийн багийн үнэлгээ, дүгнэлт болон шагнал гардуулах ёслолын хүрээнд зохион байгуулна.

Зургаа. Үнэлгээ, шалгуурын үзүүлэлтүүд

- 6.1. Илтгэлийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:
- Сэдвийн ач холбогдол, шинэлэг байдал – сонгосон асуудлын үндэслэл, өнөөгийн нөхцөл байдалтай уялдсан байдал, шинэлэг санаа, хандлага;
 - Судалгааны зорилго, асуудлын тодорхой байдал – судалгааны зорилго, зорилт, судлах асуудал хоорондын уялдаа;
 - Судалгааны арга зүйн үндэслэл – сонгосон арга, аргачлалын оновчтой байдал, шинжлэх ухааны үндэслэл;
 - Өгөгдөл, дүн шинжилгээ, эмпирик нотолгооны чанар – ашигласан мэдээллийн найдвартай байдал, боловсруулалт, шинжилгээний чанар, үр дүнгийн үндэслэлтэй байдал;
 - Дүгнэлт, санал зөвлөмжийн үндэслэл – судалгааны үр дүнтэй уялдсан, тодорхой, хэрэгжих боломжтой дүгнэлт, санал дэвшүүлсэн байдал;
 - Практик ач холбогдол, хэрэгжих боломж – орон сууцны санхүүжилт, ипотекийн зах зээл болон холбогдох салбарт ашиглах, хэрэгжүүлэх боломж;
 - Эрдэм шинжилгээний бичлэгийн чанар, эх сурвалжийн ашиглалт – бүтээлийн логик бүтэц, хэл найруулга, эх сурвалжийн чанар, эшлэл болон техникийн шаардлагыг хангасан байдал.
- 6.2. Эцсийн шатанд шалгарсан бүтээлийг дээрх шалгуураас гадна илтгэх ур чадвар, танилцуулгын бүтэц, судалгааны гол үр дүнг ойлгомжтой

илэрхийлсэн байдал болон шүүгчдийн асуултад хариулсан байдлыг харгалзан үнэлнэ.

- 6.3. Шалгаруулалтын дүнг шүүгчдийн багийн үнэлгээнд үндэслэн гаргах бөгөөд шүүгчдийн багийн шийдвэр эцсийх байна.

Долоо. Шагнал, урамшуулал

Эцсийн шатанд шалгарч илтгэлээ хэлэлцүүлсэн оролцогч (баг)-д батламж олгоно.

I-р байр: *Батламж, мөнгөн шагнал*

II-р байр: *Батламж, мөнгөн шагнал*

III-р байр: *Батламж, мөнгөн шагнал* тус тус олгоно.

Найм. Бусад зүйл

- 9.1. Бүтээлийн зохиогчийн эрх тухайн бүтээлийг ирүүлсэн оролцогчид хадгалагдах бөгөөд МИК нь сургалт, судалгаа, олон нийтэд сурталчлах зорилгоор ашиглах эрхтэй байна.
- 9.2. Бүтээлд агуулагдах мэдээлэл, тооцоолол, судалгааны үр дүн, дүгнэлтийн үнэн зөв байдлыг тухайн оролцогч өөрөө бүрэн хариуцна.
- 9.3. Нэмэлт мэдээлэл авах бол дараах хаягаар холбогдоно уу:
- Цахим шуудан: iltgel@mik.mn,
 - Утас: +976-11-328267 / 891

Зохион байгуулах комисс

2026 оны 9 дүгээр сарын 07